



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ  
**МАЛ ЭМНЭЛГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР**

Засгийн газрын IX байр, Энхтайваны өргөн чөлөө 16а,  
Баянзүрх дүүрэг, Улаанбаатар хот, 13381  
Утас/Факс: (976-51) 26 16 35,  
Цахим шуудан: vet@vet.gov.mn

2024.04.15 № 04/480  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-Т

МОНГОЛИАН ВЕТЕРИНАРИ  
КООПЕРАТИВ ДУНДЫН  
ХОРШООНЫ ДАРГА  
Д.ЗИНАМЯДАР ТАНАА

**Тодруулгад хариу өгөх тухай**

Танай байгууллагаас 2024 оны 04 дүгээр сарын 08-ны өдөр ирүүлсэн ХХААХҮЯ/20240102169 дугаар тендерийн Багц 3 "Мал эмнэлгийн лабораторийн оношилгоо, шинжилгээнд шаардагдах хэрэглэгдэхүүн, багаж хэрэгсэл" тендерт техникийн тодорхойлолт дах нэр бүхий бараанд тодруулга авах хүсэлттэй танилцаад тодруулгын дагуу дараах хариуг хүргүүлж байна. Үүнд:

1.Бараа 5. Лабораторийн цаг. Энэхүү цагийг 2023 онд нийлүүлж байсан бөгөөд техникийн тодорхойлолтыг өөрчлөн механик ажиллагаатай гараар тохируулдаг гэснийг автомат электрон цагаар сольж байсан тул техникийн тодорхойлолт зөв эсэхийг нягталж өгнө үү.

а. Өгсөн тодорхойлолтод нийцсэн цаг байна.

2.Бараа 8. Лабораторийн бээлий. Бээлийний материалыг ирүүлнэ үү.

а. Хатуу биш уян хатан чанартай резинэн материалтай бээлий байна.

3.Бараа 24. Бактериологийн гогцоо. Материал болон хэмжээний мэдээллийг ирүүлнэ үү.

а. Уутандаа 50 ш-ээр багцалсан, хайрцгандаа 5 уут байна. Полистирол материалтай.

4.Бараа 41-46. Дуран...мл. Барааны нэрийг тодорхой ирүүлнэ үү.

Бараа 41 болон 42 хувьд хэмжээсийг дахин нягтална уу.

Шилэн эдлэл нь 5,10,25,50,100,...мл гэх мэт дарааллаар дээшээ өсдөг болно.

а. 41 болон 42 нь 100 мл (хэмжээ ижил). Өөр дээрээ хэмжээстэй, эргэдэг тагтай шилэн сав байна.

5.Бараа 67. Бүдүүн хуруу шилний /рак 35мм/. Барааны нэрийг тодорхой ирүүлнэ үү.

а. Цусны сорьц авах зориулалт бүхий хуруу шилийг тогтоох, хадгалах сетка юм, /рак гэж нэрлэдэг/ 12 х.шил орох хэмжээтэй.

1334952063